



**НАЛАЙХЫН БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН
ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨААТҮГ
ДАРГЫН ТУШААЛ**

2017 оны 03 сарын 01 өдөр

Дугаар 1/06

Улаанбаатар хот

**Дотоод хяналт, баримт бичиг
нягтлан шалгах комисс томилох тухай**

Монгол улсын төрийн хяналт шалгалтын тухай хууль, Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан “Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”, Архивын тухай хуулийн 22 дугаар зүйл, “Байгууллагын архивын ажлын үндсэн заавар”-ын 9 дүгээр бүлэг, “Налайхын Барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ-ын дүрмийн 5.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Дотоод хяналт, баримт бичиг нягтлан шалгах комисс”-ыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Зөвлөлийн дарга:

Ахлах мэргэжилтэн – Н.Пүрэвсүрэн

Гишүүд:

Ахлах нягтлан бодогч – Ц.Бямбасүрэн


Хуулийн мэргэжилтэн – Б.Нямхүү

2. Холбогдох хууль тогтоомж тэдгээрт нийцүүлэн гаргасан эрх зүйн акт, дүрэм журам, заавар, стандартад дүгнэлт хийж, байгууллагын хэмжээнд зөвлөмж өгөх, үйл ажиллагааг сайжруулах талаар дэмжлэг үзүүлж, хяналт тавин ажиллахыг комиссын дарга /Н.Пүрэвсүрэн/-д үүрэг болгосугай.

3. “Дотоод хяналт, баримт бичиг нягтлан шалгах комисс”-ын ажиллах журмыг хавсралтаар баталсугай.

4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан газрын даргын 2015 оны 09 дугаар сарын 28-ны өдрийн А/49/ тоот тушаалыг хүчингүйд тооцсугай.

ДАРГА



А.БОЛДБААТАР